

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .. дугаар
сарын .. -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/1.4 дүгээр зүйлийн 1.4, 1.5 дахь хэсэг:

“1.4.“мэдэгдэл” гэж энэ хуулийн 8.3 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг;

1.5.“мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж энэ хуулийн 8.3 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг эрх бүхий этгээдээс баталсан мэдэгдэлийн маягтын дагуу эрхлэх этгээдийг.”

2/2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд бага зэргийн эрсдэлтэй үйл ажиллагаа, эсхүл тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх бага зэргийн эрсдэлтэй нэмэлт үйл ажиллагаа, эсхүл нэг удаагийн шинжтэй үйл ажиллагааг мэдэгдлээр эрхэлнэ.”

3/2.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Энэ хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4-т заасан мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны хугацаа гурван жилээс дээшгүй байна.”

4/2.4 дүгээр зүйл:

“2.4 дүгээр зүйл.Зөвшөөрөл, мэдэгдлийн баримт бичиг

1.Эрх бүхий этгээд зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтээр, эсхүл хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл олгосныг баталгаажуулан зөвшөөрлийн баримт бичиг буюу гэрчилгээ, түүнтэй адилтгах эрхийн бичиг, бусад үнэт цаас бүхий баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр олгоно.

2.Зөвшөөрлийн баримт бичиг нь зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаанд зөвшөөрөл олгосон шийдвэр, зөвшөөрлийн лавлагааны нэгэн адил эрх зүйн хүчинтэй байна.

3.Зөвшөөрлийн баримт бичгийг гээх, үрэгдүүлэх, гэмтээх, хүлээж аваагүй байх нь зөвшөөрлийг хүчингүй гэж үзэх үндэслэл болохгүй.

4.Мэдэгдлийн баримт бичиг нь эрх бүхий этгээдээс баталсан маягт байх бөгөөд цахимаар зөвшөөрөл, мэдэгдлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн байна.”

5/3.2 дугаар зүйлийн 1.4 дэх заалт:

“1.4.энэ хуулийн 8.3 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг мэдэгдэлгүй эрхэлсэн, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагааг эрхэлсэн, эсхүл хуульд заасан зөрчил илэрсэн тохиолдолд үйл ажиллагааг зогсоох.”

6/3.2 дугаар зүйлийн 2.7 дахь заалт:

“2.7.энэ зүйлийн 2.4, 2.6-д заасан шийдвэр, мэдэгдлийг хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлэх;”

7/3.2 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:

“3.Эрх бүхий этгээд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд зөвшөөрөл олгох бүрэн эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

4.Энэ хуулийн 8.3 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээд мэдэгдлийг үйл ажиллагааны зорилго, онцлог, эрсдэлийн түвшнээс хамааруулан хүн, хуулийн этгээдэд ойлгомжтой, шуурхай байдлаар нэвтрүүлнэ.”

8/4.2 дугаар зүйлийн 2.9 дэх заалт:

“2.9.зөвшөөрөл эзэмшигч, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нэр, хаяг, байршил болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан холбогдох бусад мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд эрх бүхий этгээдэд ажлын 5 өдрийн дотор мэдэгдэх.”

9/4.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагаа эрхлэх хугацаанд мэдэгдлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.”

10/5.6 дугаар зүйл:

“5.6 дугаар зүйл.Мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх журам

1.Мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд энэ хуулийн 8.3 дугаар зүйлд заасан үйл ажиллагаагаа эрхлэхээс өмнө хуульд заасан баримт бичгийг мэдэгдлийн хамт эрх бүхий этгээдэд цахимаар хүргүүлнэ.

2.Мэдэгдэл хүргүүлэлгүйгээр үйл ажиллагааг явуулахыг хориглоно.”

11/6.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Эрх бүхий этгээд энэ хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.3, 1.6, 1.7-д заасан хүчингүй болгох үндэслэл байгаа тухай мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээдэд урьдчилан мэдэгдэж, мэдэгдлийг хүргүүлсэн он, сар, өдрийг тэмдэглэлд тусгана.”

12/8.1 дүгээр зүйлийн 2.39 дэх заалт:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
2.39.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо

13/8.2 дугаар зүйлийн 1.17-1.25 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
1.17.амьтны цуглуулга хийх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.18.амьтныг сэргээн нутагшуулах, өсгөж үржүүлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.19.ан, амьтны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.20.байгаль орчны аудит хийх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.21.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.22.ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
1.23.усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
1.24.ойгоос мод бэлтгэх эрх	Ойн анги, эсхүл сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан
1.25.газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

14/8.2 дугаар зүйлийн 2.52, 2.53 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
2.52.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.53.үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо

15/8.2 дугаар зүйлийн 3.4, 3.5 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
3.4.газар зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллагын эрх олгох	Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
3.5.газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох	Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

16/8.2 дугаар зүйлийн 4.6 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
4.6.автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

17/8.2 дугаар зүйлийн 5.5-5.14 дэх заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
5.5.аудитын үйл ажиллагаа эрхлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.6.татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.7.хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.8.гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.9.гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх	Гаалийн удирдах төв байгууллага
5.10.гаалийн баталгаат барилгын талбай ажиллуулах	Гаалийн удирдах төв байгууллага
5.11.гаалийн баталгаат үйлдвэрийн газар ажиллуулах	Гаалийн удирдах төв байгууллага
5.12.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар ажиллуулах	Гаалийн удирдах төв байгууллага
5.13.гаалийн тусгай бүс байгуулах	Гаалийн удирдах төв байгууллага
5.14.татваргүй барааны дэлгүүр ажиллуулах	Гаалийн удирдах төв байгууллага

18/8.2 дугаар зүйлийн 6.14, 6.15 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
6.14.Мэргэжлийн болон техникийн боловсролын шинэ мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6.15.хүүхэд харах үйлчилгээ эрхлэх	Тухайн сум, дүүргийн Засаг дарга

19/8.2 дугаар зүйлийн 7.3-7.5 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
7.3.бүх төрлийн шатахууны бөөний, жижиглэнгийн худалдаа эрхлэх	Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7.4.түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга
7.5.түгээмэл тархацтай ашигт малтмал хайх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга

20/8.2 дугаар зүйлийн 10.16-10.21 дэх заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
10.16.архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэх	Архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
10.17.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх	Хуульчдын холбоо
10.18.өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа	Өмгөөлөгчдийн холбоо
10.19.харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
10.20.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх	Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
10.21.гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх	Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

21/8.2 дугаар зүйлийн 11.19 дэх заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
11.9.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч

22/8.2 дугаар зүйлийн 12.2-12.6 дэх заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
12.2.сувилах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
12.3.сэргээн засах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
12.4.эм барих мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
12.5.эмчлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
12.6.эх барих мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

23/8.3 дугаар зүйл:**“8.3 дугаар зүйл.Мэдэгдлийн жагсаалт**

1.Байгаль орчны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
1.1.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис,	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах	
1.2.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин боловсруулах, дахин цэнэглэх, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, засвар үйлчилгээ хийх, устгах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.3.агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах	Тухайн сум, дүүргийн Засаг дарга

2.Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
2.1.банкны нэр, байршлыг өөрчлөх	Монголбанк
2.2.банк бус санхүүгийн байгууллагын нэр, байршлыг өөрчлөх	Санхүүгийн зохицуулах хороо
2.3.даатгалын байгууллагын нэр, байршлыг өөрчлөх	Санхүүгийн зохицуулах хороо
2.4.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн салбарыг бүртгүүлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.5.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгөд өөрчлөлт оруулах	Санхүүгийн зохицуулах хороо
2.6.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн гүйцэтгэх удирдлага, оноосон нэр, хаяг байршлын өөрчлөлт оруулах	Санхүүгийн зохицуулах хороо
2.7.үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.8.үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.9.актуарчийн эрх	Санхүүгийн зохицуулах хороо
2.10.даатгалын байгууллагын эрх бүхий албан тушаалтан	Санхүүгийн зохицуулах хороо
2.11.даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.12.банк бус санхүүгийн салбар, төлөөлөгчийн газар, нэгж нээх	Санхүүгийн зохицуулах хороо
2.13.даатгагч нь өөрийн салбар, төлөөлөгчийн газраа нээх	Санхүүгийн зохицуулах хороо
2.14.үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээд нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах	Санхүүгийн зохицуулах хороо

3.Барилга, хот байгуулалтын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
3.1.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг хэвлэх	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
3.2.барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга

4.Зам, тээврийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
4.1.орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх	Аймаг, нийслэлийн Засаг дарга
4.2.тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

5.Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
5.1.үнэт цаас үйлдвэрлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

6.Соёл, боловсролын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
6.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, хуулийн этгээд кино зураг авалт хийх	Кино урлагийн зөвлөл
6.2.соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

7.Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
7.1.тамга, тэмдэг үйлдвэрлэх	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
7.2.хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх	Цагдаагийн төв байгууллага

8.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
8.1.Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх	Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
8.2.малыг гадаадад гаргахад төрөл, зүйл тус бүрд нэг удаагийн зөвшөөрөл олгох	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8.3.судалгаа, шинжилгээний зорилгоор мал үржүүлгийн бүтээгдэхүүнийг гадаадад гаргахад ижил зүйлийн тав хүртэл сорьцод нэг удаагийн зөвшөөрөл олгох	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8.4.ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг импортлох, худалдаалах	Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
8.5.мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүн гадаадад гаргах	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

9.Эрүүл мэндийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
9.1.ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис худалдах болон үйлчилгээ эрхлэх	Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

2 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Захиргааны ерөнхий хууль,” гэж, 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хүчингүй болгох,” гэсний дараа “эсхүл мэдэгдлээр эрхлэх” гэж, 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтын “зөвшөөрөл олгох” гэсний дараа “, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэдэгдэл хүлээн авах” гэж, мөн заалтын “хэрэгжүүлэхээр заасан,” гэсний дараа “, эсхүл хуулиар мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаатай холбогдох харилцааг хэрэгжүүлэхээр заасан” гэж, 1.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “зөвшөөрөл,” гэсний дараа “мэдэгдэл,” гэж, мөн хэсгийн “бүртгэл” гэсний дараа “, баталгаажуулалт” гэж, мөн зүйлийн 13 дахь хэсгийн “эзэмшигч” гэсний дараа “, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж, мөн зүйлийн 16 дахь хэсгийн “8.2” гэсний дараа “, 8.3” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийн “Зөвшөөрөл” гэсний дараа “, Мэдэгдэл” гэж, 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Байгалийн баялаг” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 3.2 дугаар зүйлийн гарчгийн “эрх” гэсний дараа “, үүрэг” гэж, 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “эрхлэх этгээд” гэсний дараа “, 8.3 дугаар зүйлд заасан мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж, 4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “эзэмшигч” гэсний дараа “, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж, Тавдугаар бүлгийн гарчгийн “СУНГАХ” гэсний дараа “, МЭДЭГДЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ” гэж, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “8.14,” гэсний дараа “8.15,” гэж, 6.2 дугаар зүйлийн 1.1, 1.7 дахь заалтын “эзэмшигч” гэсний дараа “мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж, мөн зүйлийн 1.3 дахь заалтын “эзэмшигч” гэсний дараа “, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж, 6.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “этгээд” гэсний дараа “, эсхүл мэдэгдлээр үйл ажиллагаа эрхэлж байсан этгээд” гэж, 8.1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтын “нутагшуулах” гэсний дараа “, өсгөж үржүүлэх” гэж, 8.2

дугаар зүйлийн 6.9 дэх заалтын “засварлах” гэсний дараа “зөөж тээвэрлэн” гэж, 9.3 дугаар зүйлийн 2.2 дахь заалтын “8.2” гэсний дараа “, 8.3” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл эрсдлийн үнэлгээний дагуу тогтоосон энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөл /цаашид “зөвшөөрөл” гэх/, 8.3 дугаар зүйлд заасан мэдэгдлээр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг холбогдох хуульд нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно.”

2/1.5 дугаар зүйлийн 1.5, 1.6 дахь заалт:

“1.5.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
1.6.иргэн, хуулийн этгээд, төрийн ашиг сонирхлын тэнцвэрт байдлыг хангах;”

3/2.1 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд дунд зэргийн эрсдэлтэй үйл ажиллагаа, эсхүл тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх нэмэлт үйл ажиллагаа, эсхүл тусгай болзол, шаардлагыг хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа, эсхүл судалгаа шинжилгээний болон ахуйн зориулалтаар байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахад энгийн зөвшөөрөл олгоно.”

4/3.2 дугаар зүйлийн 2.6 дахь заалт:

“2.6.энэ хуулийн 8.3 дугаар зүйлд заасан мэдэгдлийг хүлээн авсан даруйд бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах;”

5/4.2 дугаар зүйлийн 2.5 дахь заалт:

“2.5.мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлснээс хойш ажлын 3 өдрийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх;”

6/8.1 дүгээр зүйлийн 7.9 дэх заалт:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
7.9.дотоод, гадаадын хуулийн этгээд Монгол Улсад боловсролын сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаа	Чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага

7/8.1 дүгээр зүйлийн 14.1-14.22 дахь заалт:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
14.1. 0.1-100 МВт-ын эрчим хүчний эх үүсвэрийн засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
14.2. 100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэрийн засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
14.3. 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
14.4. 110 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
14.5. 0.07-8.0 МПа даралттай зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
14.6. 8.0 МПа-аас дээш даралттай зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
14.7. Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

4 дүгээр зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн нэрийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “тогтоохтой” гэснийг “тогтоох, мэдэгдэлтэй” гэж, 1.2 дугаар зүйлийн гарчгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “этгээдийг” гэснийг “этгээд болон мэдэгдлийн жагсаалт, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээдийг” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Хуулиар зөвшөөрөлтэйгөөр” гэснийг “Энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл, мэдэгдлээр” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “хооронд зөвшөөрөл авах, олгох харилцаанд энэ хууль хамаарахгүй” гэснийг “хоорондын зөвшөөрлийн харилцаанд үйлчлэхгүй” гэж, 1.5 дугаар зүйлийн гарчгийн “Зөвшөөрөл олгох, сунгах, шинээр бий болгоход” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн харилцаанд” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “зөвшөөрөл олгох, сунгах болон зөвшөөрөлтэй” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдэлтэй” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Хуульд” гэснийг “Энэ хуульд” гэж, мөн хэсгийн “аливаа” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “ажиллагаанд” гэснийг “ажиллагаа, эсхүл мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаанд” гэж, мөн зүйлийн 14 дэх хэсгийн “үнэлгээ хийх зарчмыг баримтлан олон улсын жишиг, стандартыг харгалзана” гэснийг “үнэлгээ хийнэ” гэж, мөн зүйлийн 16 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдлийг” гэж, мөн зүйлийн 17 дахь хэсгийн “болгохтой” гэснийг “болгох болон мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаатай” гэж, 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа, эсхүл тусгай болзол, шаардлагыг хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа, эсхүл

ашиг олох зорилгоор болон” гэснийг “өндөр зэргийн эрсдэлтэй үйл ажиллагаа, эсхүл” гэж, 2.2 дугаар зүйлийн гарчгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “таван” гэснийг “арван” гэж, мөн хэсгийн “гурван” гэснийг “таван” гэж, мөн зүйлийн гарчгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, Гуравдугаар бүлгийн гарчгийн “ЭТГЭЭД,” гэснийг “ЭТГЭЭДИЙН БҮРЭН ЭРХ, ҮҮРЭГ,” гэж, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтын “эсэхэд” гэснийг “эсэх, мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаанд хуульд заасны дагуу” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтын “тухайн зөвшөөрлийн” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн заалтын “эзэмшигчээс” гэснийг “эзэмшигч, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээдээс” гэж, Дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “ЭЗЭМШИГЧИД” гэснийг ЭЗЭМШИГЧ, МЭДЭГДЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ ЭТГЭЭДЭД” гэж, мөн гарчгийн “ЭЗЭМШИГЧИЙН” гэснийг “ЭЗЭМШИГЧ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ ЭТГЭЭДИЙН” гэж, 4.1 дүгээр зүйлийн гарчгийн “эзэмшигчид” гэснийг “, эзэмшигч, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэгч этгээдэд” гэж, 4.2 дугаар зүйлийн гарчгийн “эзэмшигчийн” гэснийг “эзэмшигч, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээдийн” гэж, мөн зүйлийн 1.1 дэх заалтын “зөвшөөрөлд” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдэлд” гэж, 1.5 дахь заалтын “зөвшөөрлийн” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн заалтын “зөвшөөрөлтэй” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдэлтэй” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 2.3 дахь заалтын “зөвшөөрөлд” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдэлд” гэж, мөн хэсгийн 2.8 дахь заалтын “зөвшөөрлийн” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны” гэж, 4.2 дугаар зүйлийн 2.9 дэх заалтын дугаарыг “2.10” гэж, 5.6 дугаар зүйлийн дугаарыг “5.7” гэж, 6.2 дугаар зүйлийн гарчгийн “Зөвшөөрлийг” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийг” гэж, мөн зүйлийн 1.6 дахь заалтын “зөвшөөрлийг авахдаа” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн үйл ажиллагаа эрхлэхдээ” гэж, 6.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дугаарыг “5” гэж, Долдугаар бүлгийн гарчгийн, “ЗӨВШӨӨРЛИЙН” гэснийг “ЗӨВШӨӨРӨЛ, МЭДЭГДЛИЙН” гэж, 7.1 дүгээр зүйлийн гарчгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “мэдээллийг агуулсан зөвшөөрлийн” гэснийг “мэдээлэл, мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны мэдээллийг агуулсан зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “шийдвэрийг” гэснийг “шийдвэр, мэдэгдлийг” гэж, 4 дэх хэсгийн “шийдвэрийг зөвшөөрлийн” гэснийг “шийдвэр, мэдэгдлийг” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдлийг” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “шийдвэрийн” гэснийг “шийдвэр, мэдэгдлийн” гэж, Наймдугаар бүлгийн гарчгийн “ЗӨВШӨӨРЛӨӨР” гэснийг “ЗӨВШӨӨРӨЛ, МЭДЭГДЛЭЭР” гэж, 8.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “Засгийн газар” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн зүйлийн 1.8 дахь заалтын “генетикийн” гэснийг “генетик” гэж, мөн зүйлийн 1.20 дахь заалтын “Удирдан зохицуулах зөвлөл” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн зүйлийн 1.23 дахь заалтын “аймаг, нийслэлийн” гэснийг “аймгийн” гэж, 1.24, 1.25 дахь заалтын “сум, дүүргийн” гэснийг “аймгийн” гэж, мөн зүйлийн 1.27 дахь заалтын “алба” гэснийг “газар” гэж, 1.28 дахь заалтын “Тухайн сав газрын захиргаа” гэснийг “Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга” гэж, 1.29 дэх заалтын “ойн анги, эсхүл тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч” гэснийг “аймаг, нийслэлийн Засаг дарга” гэж, мөн зүйлийн 7.2 дахь заалтын “их сургууль, дээд сургууль, коллежийн” гэснийг “дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын” гэж, 7.4 дэх заалтын “төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалт эрхлэх үйл ажиллагаа” гэж, 7.6 дахь заалтын “цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалт эрхлэх үйл ажиллагаа” гэж, 7.7 дахь заалтын “ерөнхий боловсролын сургууль байгуулах” гэснийг “ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалт эрхлэх үйл ажиллагаа”

гэж, мөн зүйлийн 8.1, 8.3 дахь заалтын “Засгийн газар” гэснийг “Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 8.2 дахь заалтын “Засгийн газар” гэснийг “Хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 8.2 дугаар зүйлийн 6.2 дахь заалтын “дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах” гэснийг “дээд боловсролын шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэх үйл ажиллагаа” гэж, 6.3 дахь заалтын “сургууль байгуулах” гэснийг “ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол болон дээд боловсрол эзэмшүүлэх сургалт эрхлэх үйл ажиллагаа” гэж, 6.4 дэх заалтын “их сургууль, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль байгуулах” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын харьяа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ерөнхий боловсрол болон сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх” гэж, мөн зүйлийн 10.8 дахь заалтын “зорилгоор галт зэвсэг” гэснийг “болон спортын тэмцээн, сургалтад оролцох зорилгоор Монгол Улсын иргэн иргэний зориулалттай галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг” гэж, 9.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэснийг “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 9.3 дугаар зүйлийн 2.2 дахь заалтын “зөвшөөрлийн” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй

5 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Хуулиар” гэснийг, 1.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Хуульд зааснаас бусад тохиолдолд” гэснийг, 5.4 дүгээр зүйлийг, 7.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн “зөвшөөрлийн” гэснийг, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг, 8.1 дүгээр зүйлийн 1.2, 1.4, 1.6, 1.7, 1.9, 1.10, 1.11, 1.12, 1.13, 1.15, 1.30, 1.31 дэх заалтыг, мөн зүйлийн 1.16 дахь заалтын “эм” гэснийг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 2.13, 2.20, 3 дахь хэсгийн 3.6, 3.7 дахь заалтыг, мөн зүйлийн 5 дахь хэсгийн 5.3, 5.5, 5.12 дахь заалтыг, мөн зүйлийн 6 дахь хэсгийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.6, 6.7, 6.8, 6.9, 6.10, 6.11, 6.12 дахь заалтыг, мөн зүйлийн 7 дахь хэсгийн 7.8 дахь заалтыг, мөн зүйлийн 8 дахь хэсгийн 8.4 дэх заалтыг, 8.22 дахь заалтын “болон түүнтэй холбогдсон бусад” гэснийг, 8.29, 8.30 дахь заалтыг, 11 дэх хэсгийн 11.3, 11.6, 11.7, 11.8, 11.9, 11.11, 11.13 дахь заалтыг, 12 дахь хэсгийн 12.6, 12.10, 12.13 дахь заалтыг, 13 дахь хэсгийн 13.1, 13.2, 13.3, 13.4, 13.5, 13.15 дахь заалтыг, 8.2 дугаар зүйлийн 1.10 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 2.7, 2.27, 2.28, 2.32, 2.41, 2.42, 2.50 дахь заалтыг, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 3.2, 3.3 дахь заалтыг, 6.11, 6.13 дахь заалтыг, 11.2, 11.3, 11.8 дахь заалтыг, 9.3 дугаар зүйлийн 2.3 дахь заалтын “зөвшөөрлийн ангилалд үндэслэн” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн **1.3 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг,** 3.1 дүгээр зүйлийг, 4.2 дугаар зүйлийн 2.4 дэх заалтыг, 8.1 дүгээр зүйлийн 1.3, 1.13, 1.19 дэх заалтыг, мөн зүйлийн 7 дахь хэсгийн 7.1, 7.3, 7.10, 7.11, 7.12 дахь заалтыг, 8.26 дахь заалтыг, 12 дахь хэсгийн 12.4 дэх заалтыг, 8.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтыг, мөн зүйлийн 2.2, 2.27, 2.33, 2.43, 2.45, 2.47, 2.48, 2.49, 2.51 дэх заалтыг, мөн зүйлийн 5 дахь хэсгийн 5.2 дахь заалтыг, мөн зүйлийн 6.5 дахь заалтыг, 7.2 дахь заалтыг, 10.9 дэх заалтыг, 8.2 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны .. дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

